



БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/19/СТА-ТШЗ

БУЛГАН АЙМАГ 2019 ОН

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд
Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 7034-2580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn

Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2495 Цахим хаяг: sodnomp@audit.gov.mn

Аудитор: Г.Цэрэнлхам
Утас: 9907-9641 Цахим хаяг: tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу: Цахим хуудас: www.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.13. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал.....	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	Error! Bookmark not defined.

Аудитын гэрчилгээ



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.04.27 № *92*

танай _____ -ны № _____ т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БУЛГАН СУМЫН ДӨРӨВДҮГЭЭР Г
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
П.АРИУНАА ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020187

Аудитын гол асуудал

Аймгийн Засаг даргын захирамжтай давхардуулан сумын Засаг даргын захирамжаар үр дүнгийн урамшууллыг олгосон, ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлээгүй шууд гэрээгээр худалдан авах босго үнээс давсан хүүхдийн хоолны материалын худалдан авалтыг харьцуулалтын аргаар тендер зохион байгуулаагүй, хүүхдийн хоолны норматив зардлыг хэтрүүлэн зарцуулсан, санхүү, төсвийн зүй зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зүй зохистой, зориулалтын дагуу зарцуулаагүй нийт 40049,2 мянган төгрөг алдаа, зөрчил илэрсэн нь санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх", "Үнэн зөв байдал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

Аудитын тайлан

2.1. Оршил

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч П.Ариунаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам хариуцаж хэрэгжүүлэв.

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 1/04 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Булган сумын 4-р цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Бага насны хүүхдийн бие бялдар, нийгэмшил, урлаг уран сайхан, сэтгэн бодох чадвар, бие даасан чанарыг хөгжүүлэхэд чиглэсэн мэдлэг, боловсрол, хүмүүжил эзэмшүүлэх ая таатай орчин бүрдүүлэхэд оршино.

Булган сумын 4-р цэцэрлэгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Боловсролын тухай хууль,
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол “Журам батлах тухай”
- Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ”
- Засгийн газрын 2019 оны 25 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийн шинэчлэл тогтоох тухай”

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Булган сумын 4-р цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Булган сумын 4-р цэцэрлэг санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Си Ти Эс” программ хангамж ашигладаг байна. Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Булган сумын 4-р цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөлийн үе шатанд 27 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 340413.5 мянган төгрөгөөс тооцон 3404.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2 хувиар буюу 9294,5 мянган төгрөгөөр тооцсон нь жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн орлогоос тооцсон бөгөөд өссөн дүнгээр тайлан гаргадагтай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 1451.6 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	Б	1	2	3=2-1
1	Мөнгөн хөрөнгө	25983.4	39784.4	13801.0
2	Авлага	52.5	174.7	122.1
3	Урьдчилгаа			
4	Бараа материал	25421.1	39298.9	13877.7
5	Нөөцийн бараа	509.6	3108	-198.8
6	Үндсэн хөрөнгө	180573.1	176945.9	-3627.1

7	Нийт хөрөнгө	206556.5	216730.4	10173.8
8	Өр төлбөр		552.4	552.4
9	Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	180573.1	176945.9	-3627.1
10	Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	206556.5	216730.4	10173.8

Бараа материалын дансны үлдэгдэл 13877.7 мянган төгрөгөөр өссөн нь хүнсний материал 5077.6, бусад хангамжийн материал 9500.6 мянган төгрөгөөр өссөн, бичиг хэрэг 55.5, аж ахуйн материал 13.2 сэлбэг хэрэгсэл 417.6, түлш шатах тослох материал 74.4 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Үүнд Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалыг хэрэгжүүлээгүй нөөцийн барааг буруу ангилан бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10173.8 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь 12689.8 компьютер тоног төхөөрөмж, тавилга эд хогшил 6068.0 мянган төгрөгөөр худалдан авч, машин тоног төхөөрөмж 763.0, тавилга эд хогшил 623.6 мянган төгрөгийн хөрөнгийг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр акталсан. Мөн тайлант онд барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, бусад хөрөнгө, программ хангамжид 22212.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь нөлөөлжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 552.4 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд гэрэл цахилгаан, хоолны зардал хүрэлцээгүйгээс үүссэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Булган сумын 4-р цэцэрлэгийн тайлант онд улсын төсвөөс 319962.7, орон нутгийн төсвөөс 46718.6 нийт 366681.3 мянган төгрөгийн санхүүжилт авахаас бүрэн санхүүжигдэн, гүйцэтгэлээр 365897.6 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан 783.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1. Улсын төсвөөс	319962.7	319179.0	783.7	99.7
2. Орон нутгийн төсвөөс	46718.6	46718.6	-	100.0
Нийт дүн	366681.3	365897.6	783.7	99.7

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 27 эрсдэл, гүйцэтгэлийн үе шатанд 1 эрсдэл нэмж тодорхойлж нийт 28 эрсдэлд горим сорил хэрэгжүүлжээ.

Аудитаар нийт 29821.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 171.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 29018.7 мянган төгрөгийн

зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 631.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг өглөө.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

№	Шийдэл	(Мянган төгрөгөөр)		
		Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	631.5	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	171.2	
3	Албан шаардлага өгсөн	2	29018.7	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	6	29821.4	

Аудитаар 53995.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил илэрснээс 2 төлбөрийн акт тогтоож, 52517.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж Үүнд:

1. Аймгийн Засаг даргын захирамжтай давхардуулан сумын Засаг даргын 2018 оны Б/21 тоот захирамжаар Булган сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгч П.Ариунаад үр дүнгийн урамшуулал 171200 /Нэг зуун далан нэгэн мянга хоёр зуу/ төгрөгийг хэтрүүлж олгосон байна. Энэ нь санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15-д “Аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх”, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-д “Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.7-д “..... Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана” гэсэн заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах, төсвийг хохиролгүй болгохоор төлбөрийн акт тогтоосон.

2. Булган сумын 4-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2019 оны Б/29 тоот тушаалаар ахмадын санд цалингийн зардлаас зориулалт бусаар 151.2 мянган төгрөг шилжүүлсэн байна. Энэ нь “тохиолдсон байх”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан эдийн засгийн ангиллыг зөрчсөн тул зөрчлийг арилгах, таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

3. Шууд худалдан авах босго үнээс давсан 28867.5 мянган төгрөгийн хүүхдийн хоолны материалын худалдан авалтыг харьцуулалтын аргаар тендер зохион байгуулаагүй байна. Энэ нь “тохиолдсон байх”, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т *”Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно”*, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнийн 2-т *”Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 10.0 сая төгрөг”* гэсэн заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлага өгсөн.

Аудитаар илэрсэн 631.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Дараагийн аудитаар тогтмол зардлыг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулсан талаар, мөн худалдаа авалт бүрд цахим и-баримт болох анхан шатны төлбөрийн баримтаар баталгаажсан эсэх
- Төсвийн төвлөрүүлэн захирагчид төсвийг захиран зарцуулахад хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд эрх зүйн акт гаргаж байх зөвлөмж хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 46 мэдээллийг мэдээлэхээс 22 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Зарим мэдээллийн хувьд хугацаанд мэдээлсэн боловч чанаргүй, өөр байгууллагын мэдээлэл, иргэдийг үнэн бодит мэдээллээр хангах боломжгүйгээр байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Булган сумын 4-р цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сургалтын хичээлийн жил дуусахад 2019 оны 05 дугаар сарын 31-ны байдлаар түргэн муудан шинж чанартай, удаан хадгалах боломжгүй ихээхэн хэмжээний буюу 453.3 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байна.

Энэ нь тохиолдсон байх, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн Төсвийн зарчмыг хэрэгжүүлэх 6.4-д “Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл:

Хугацаа дууссан, удаан хадгалсан хүнсний материалаар хүүхдийн хоол бэлтгэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг хэрэгжүүлэн төсвийг зүй зохистой удирдан зохион байгуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн. Цаашид хэрэгжүүлэн ажиллана.

2. Үндсэн хөрөнгийн тайлантай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хүчингүй болсон Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын хамтарсан 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан анхан шатны баримтаар ажил гүйлгээг хийсэн байна.

Энэ нь “Үнэн зөв байдал” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг хэрэгжүүлээгүй байна.

2.2. Эрсдэл:

Худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүйгээр төсвийн зарлага хэт үрэлгэн зарцуулагдаж, бэлтгэн нийлүүлэгч байгууллага нь татварын орлого тооцогдох борлуулалтын орлогоо бууруулж тайлагнах нөхцөл үүсгэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуй нэгж, байгууллагын удирдлага хүргүүлнэ”, 19 дүгээр зүйлийн 19.1.3-д “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, мөн анхан шатны баримтын бүрдлийг хангаж, хүчин төгөлдөр баримтаар ажил гүйлгээг бүртгэх, түүнд тавих хяналтыг сайжруулах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн. Цаашид хэрэгжүүлэн ажиллана.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Түлш халаалтын зардлаас 3-р цэцэрлэгийн шатахууны зардлыг, хүүхдийн хоолны зардлаас материалын зардал төлсөн төлсөн байна.

3.2. Эрсдэл:

Төсвийн зарцуулалтад Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллаагүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалыг мөрдөж, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг үйл ажиллагаандаа баримталж ажиллах зөвлөмж өгөв.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн. Цаашид хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

1. Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>25,983,437.00</u>	<u>39,784,481.00</u>
33	АВЛАГА	52,594.00	174,733.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	52,594.00	174,733.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,421,193.00	39,298,918.00
354	Хангамжийн материал	25,421,193.00	39,298,918.00
35410	Бичиг хэргийн материал	85,500.00	30,000.00
35420	Аж ахуйн материал	654,900.00	641,680.00
35430	Сэлбэг хэрэгсэл	753,518.00	335,878.00
35440	Түлш, шатах тослох материал	142,420.00	68,000.00
35450	Барилгын засварын материал	50,500.00	50,500.00
35460	Хүнсний материал	2,923,445.00	7,861,310.00
35470	Бусад хангамжийн материал	20,810,910.00	30,311,550.00
36	НӨӨЦИЙН БАРАА	509,650.00	310,830.00
36600	Бусад нөөц	509,650.00	310,830.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>180,573,080.64</u>	<u>176,945,933.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	180,573,080.64	176,945,933.37
392	Биет хөрөнгө	147,223,080.64	143,595,933.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	118,960,403.42	118,960,403.42
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(15,127,651.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,596,818.00	38,523,618.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(13,937,639.82)	(17,498,439.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,975,172.99	30,419,572.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,371,673.95)	(11,681,570.89)
393	Биет бус хөрөнгө	33,350,000.00	33,350,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	33,350,000.00	33,350,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>206,556,517.64</u>	<u>216,730,414.37</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	=	<u>552,474.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	552,474.00
413	Өглөг	-	552,474.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	552,474.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>206,556,517.64</u>	<u>216,177,940.37</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	206,556,517.64	216,177,940.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	76,649,075.00	76,649,075.00
51101	Өмч: - төрийн	76,649,075.00	76,649,075.00
512	Хуримтлагдсан үр дүн	(31,070,640.31)	(21,449,217.58)
51210	Өмнөх үеийн үр дүн	(31,070,640.31)	(31,070,640.31)
51220	Тайлант үеийн үр дүн	-	9,621,422.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	160,978,082.95	160,978,082.95

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	206,556,517.64	216,730,414.37
---	--	-----------------------	-----------------------

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	292,468,200.00	366,681,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	313,618,700.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	313,618,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	313,618,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,468,200.00	53,062,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,865,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,865,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	603,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	603,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	53,062,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	53,062,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	298,185,748.24	356,927,877.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	298,185,748.24	356,927,877.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,313,548.24	355,443,137.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	154,021,533.00	211,573,303.00
210101	Үндсэн цалин	134,338,333.00	164,093,274.00
210102	Нэмэгдэл	6,059,600.00	19,777,487.00
210104	Урамшуулал	13,623,600.00	27,702,542.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,567,669.00	26,228,924.43
210201	Тэтгэврийн даатгал	13,231,509.00	17,887,504.91
210202	Тэтгэмжийн даатгал	1,128,393.00	2,104,463.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,279,356.00	1,668,581.10
210204	Ажилгүйдлийн даатгал	265,282.00	417,268.02
210205	Эрүүл мэндийн даатгал	2,663,129.00	4,151,107.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,287,280.00	52,264,237.00
210301	Гэрэл, цахилгаан	3,784,921.00	3,457,859.00
210302	Түлш, халаалт	44,021,305.00	43,751,900.00
210303	Цэвэр, бохир ус	4,481,054.00	5,054,478.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,312,683.00	4,268,305.00
210401	Бичиг хэрэг	715,800.00	825,900.00
210402	Тээвэр, шатахуун	170,000.00	262,294.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	109,083.00	133,091.00
210404	Ном, хэвлэл	-	198,820.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	251,700.00	126,700.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	66,100.00	17,100.00
210408	Бараа материал акталсны зардал	-	2,704,400.00
2105	Нормативт зардал	39,193,197.00	34,962,536.00
210502	Хоол, хүнс	38,407,822.00	34,081,595.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	785,375.00	880,941.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,589,900.00	2,520,175.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	198,000.00
210604	Урсгал засвар	3,589,900.00	2,322,175.00
2107	Томилолт, зочны зардал	84,000.00	36,000.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	36,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,800.00	136,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,800.00	136,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,060,486.24	23,453,157.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,234,116.00	551,810.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	28,000.00	648,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,798,370.24	22,252,947.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,872,200.00	1,484,739.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,872,200.00	700,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,872,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	700,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	975.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	975.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	783,764.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	783,764.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(5,717,548.24)	9,753,422.80
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,711,574.90	132,000.07
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,711,574.90	132,000.07
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(6,711,574.90)	(132,000.07)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(12,429,123.14)	9,621,422.73

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөг/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	292,468,200.00	366,681,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	313,618,700.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	313,618,700.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	-	313,618,700.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,468,200.00	53,062,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	291,865,000.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,865,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	603,200.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	603,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	53,062,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	53,062,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	288,372,254.00	347,923,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288,372,254.00	347,923,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	273,500,054.00	346,438,760.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,974,306.00	211,695,442.00
210101	Үндсэн цалин	134,291,106.00	164,215,413.00
210102	Нэмэгдэл	6,059,600.00	19,777,487.00
210104	Урамшуулал	13,623,600.00	27,702,542.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,632,490.00	26,228,924.43
210201	Тэтгэврийн даатгал	12,265,590.00	17,887,504.91
210202	Тэтгэмжийн даатгал	1,098,600.00	2,104,463.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,637,026.00	1,668,581.10
210204	Ажилгүйдлийн даатгал	219,900.00	417,268.02
210205	Эрүүл мэндийн даатгал	2,411,374.00	4,151,107.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,730,450.00	51,804,600.00
210301	Гэрэл, цахилгаан	3,784,921.00	3,057,722.00
210302	Түлш, халаалт	43,464,475.00	43,692,400.00
210303	Цэвэр, бохир ус	4,481,054.00	5,054,478.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,484,413.00	5,174,365.00
210401	Бичиг хэрэг	86,500.00	115,500.00
210402	Тээвэр, шатахуун	87,650.00	216,574.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	109,083.00	133,091.00
210404	Ном, хэвлэл	54,500.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,146,680.00	4,709,200.00
2105	Норматив зардал	35,673,259.00	45,485,764.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	58,000.00	51,800.00
210502	Хоол, хүнс	35,034,059.00	38,867,123.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	581,200.00	6,566,841.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,685,280.00	1,257,025.00
210604	Урсгал засвар	6,685,280.00	1,257,025.00
2107	Томилолт, зочны зардал	84,000.00	84,000.00
210702	Дотоод албан томилолт	84,000.00	84,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,800.00	196,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,800.00	196,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,039,056.00	4,512,140.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,302,756.00	2,679,260.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	736,300.00	1,832,880.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,872,200.00	1,484,739.57
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,872,200.00	700,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	14,872,200.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	700,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	975.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	975.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	783,764.57
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	783,764.57
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,095,946.00	18,757,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,095,946.00	18,757,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,095,946.00	18,757,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,095,946.00	18,757,800.00
222001	Тоног төхөөрөмж	4,095,946.00	18,757,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,095,946.00)	(18,757,800.00)

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,649,075.00	160,978,082.95	(31,070,640.31)	206,556,517.64
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	76,649,075.00	160,978,082.95	(31,070,640.31)	206,556,517.64
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,649,075.00	160,978,082.95	(31,070,640.31)	206,556,517.64
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	76,649,075.00	160,978,082.95	(31,070,640.31)	206,556,517.64
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	76,649,075.00	160,978,082.95	(31,070,640.31)	206,556,517.64
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	9,621,422.73	9,621,422.73
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	76,649,075.00	160,978,082.95	(21,449,217.58)	216,177,940.37